



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/43

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сум орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан экологи, нийгэм эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах, төлөвлөлтгүй тэлэлтийг зогсоох, өсөлтийн менежментийг зохицуулах, газар ашиглалтын хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор “Зүүн мөрөн хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол, шинэчлэл хийх ажлын даалгаврыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын БХБХ-ийн дарга)

Г.Даваадорж (“Хөвсгөл-Эрчим хүч” ХХК-ийн ерөнхий инженер)

Ш.Нямханд (“Хөвсгөл Дулааны станц” ТӨХК-ийн ерөнхий инженер)

Д.Сүхээ (“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ерөнхий инженер)

Ж.Лувсанням (Аймгийн “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер)

Э.Даваахүү (Мөрөн сумын архитектор, дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Х.Даваасүрэн (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, явцыг тухай бүр танилцуулан ажиллахыг Ажлын хэсэг (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН